



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 06 сарын 26 өдөр

Дугаар А/258

Арвайхээр

Г Үер, усны ослоос урьдчилан сэргийлэх Г
талаар авах зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Өвөрхангай аймгийн хэмжээнд гол, тогтоол усанд иргэдийг живж осолдохоос урьдчилан сэргийлэх зорилгоор Онги, Орхон голын эрэг дагуу амралт, аялал, зугаалгаар явж буй иргэдийн аюулгүй байдлыг хангаж, хөдөлгөөнт болон явган эргүүлийг 2020 оны 06 дугаар сарын 25-ны өдрөөс 09 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэл хугацаанд ажиллуулсугай.

2.Хөдөлгөөнт завьт эргүүл ажиллуулахад шаардагдах 918,000 (есөн зуун арван найман мянга) төгрөг, Сэрэмжлүүлэг самбар хийж байршуулахад 437,350 (дөрвөн зуун гучин долоо мянга гурван зуун тавь төгрөг, хоол хүнсний зардал 1,296,000 (нэг сая хоёр зуун ерэн зургаан мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн сангаас зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ц.Ганболд)-д зөвшөөрсүгэй.

3.Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Аймгийн Засаг даргын орлогч (И.Доржсүрэн), хяналт шалгалт, үүрэг чиглэл удирдлагаар хангаж ажиллахыг Онцгой байдлын газрын дарга, дэд хурандаа (Т.Мөнхдорж), Цагдаагийн газрын дарга, хурандаа (О.Ганбат) нарт тус тус даалгасугай.

4.Үер усны аюулаас урьдчилан сэргийлэх чиглэлээр хийх ажлын төлөвлөгөө гарсантай холбоотой албан байгууллагуудад тусгаж өгсөн ажлыг үр дүнтэй зохион байгуулж хамтран ажиллахыг холбогдох байгууллагын дарга, эрхлэгч нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100571